



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/34

Номгон

Г Ноос, ноолууран бүтээгдэхүүн холбож оёх
сургалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.3 дугаар зүйлийн 30.3.4, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хөдөө аж ахуйн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ноос ноолуурын салбарт боловсон хүчнийг нэмэгдүүлэх, аймаг орон нутагт ажлын байр шинээр бий болгох зорилгоор ноос ноолууран бүтээгдэхүүн холбож оёх буюу кетлетийн сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, сургалтад шаардагдах төсвийн санхүүжилтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сургалтад шаардагдах 5.500.000 (Таван сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д. Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Ноос ноолууран бүтээгдэхүүн холбож оёх түр сургалтад хамрагдсан иргэдтэй Хамтын ажиллагааны гэрээ байгуулан, гэрээнд хяналт тавьж ажиллахыг Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ний гүйцэтгэх захирал (Б.Наранбаяр)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА




Д.МӨНХСАЙХАН

642312035

2

Аймгийн Засаг даргын ... дүгээр
сарын ... -ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт




**"НООС НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮН ХОЛБОЖ ОЁХ"
ТҮР СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн элементүүдийн нэр	Цаг		
			Онол	Дадлага	Бүгд
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм	2	2	4
		Нэхмэл хувцасны дамжлага, бүрдэл хэсэг	4	4	8
		Тоног төхөөрөмжийн танилцуулга	2	2	4
2	Цамц оёх	Мөр залгаж оёх	2	3	5
		Эгнээ барьж оёх	2	2	4
		Ханцуй залгаж, сугалгаа оёх	2	3	5
		Зах гогцоогоор сүвлэж оёх	2	4	6
		Цахилгааны эмжээр барьж оёх	1	1	2
		Чанар шалгах	2	2	4
3	Майк оёх	Мөр залгаж оёх	2	2	4
		Зах гогцоогоор сүвлэж оёх	2	3	5
		Эмжээр барьж оёх	2	2	4
		Сугалгаа оёх	2	2	4
		Чанар шалгах	2	2	4
4	Өмд оёх	Оруулга оёх	2	2	4
		Өмдний шуумаг оёх	2	2	4
		Эмжээр гогцоогоор оёх	2	3	5
		Резин сүвлэх	2	2	4
Нийт			37	43	80

3

Аймгийн Засаг даргын *2004* Оны *07* дүгээр
сарын *25* -ны өдрийн *224* дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



КЕТЛЕТИЙН СУРГАЛТАД ХЭРЭГЛЭГДЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Санхүүжилтийн эх үүсвэр
1	2	3	4	5	6	7
1	Сандал	ш	10	15,000	150,000	БҮХК ХХК
2	Метр	ш	20	3,000	60,000	БҮХК ХХК
3	Тастагч	ш	20	4,000	80,000	БҮХК ХХК
4	Хайч	ш	20	15,000	300,000	БҮХК ХХК
5	Утас	боодол	10	150,000	1,500,000	Аймгийн ЗДТГ
6	Оёдлын машины тос	литр	1	20,000	20,000	БҮХК ХХК
7	Оёх материал	ш	150	30,000	4,500,000	БҮХК ХХК
8	Цамцны зах	ш	200	6,500	1,300,000	БҮХК ХХК
9	Уртасгагч залгуур	ш	5	30,000	150,000	БҮХК ХХК
10	Гэрэл	ш	5	30,000	150,000	БҮХК ХХК
11	Гар ороогч	ш	1	250,000	250,000	БҮХК ХХК
12	Шохой	ш	4	5,000	20,000	БҮХК ХХК
13	Оёдлын утасны патрон	ш	50	1,000	50,000	БҮХК ХХК
14	Уурын индүү	ш	1	170,000	170,000	БҮХК ХХК
16	Сургагч багшийн урамшуулал		2	2 000 000	5 000 000	Аймгийн ЗДТГ
	Кетлетийн машины тээврийн зардал		1	500,000	500,000	БҮХК ХХК
	Нийт				13 200 000	

_____ оОо _____